



ГАДААДЫН ЦӨРГИЙН АНБА, АМЬДРАЛ

**Хятад, Орос, Израйлийн хил хамгаалалт,
түүний онцлог**

Нэг. БНХАУ-ын хил хамгаалалт

БНХАУ Ази тивийн зүүн хэсэгт номхон далайн баруун эргээр байрладаг. 9,6 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй улсын хилийн хойд цэгээс өмнөд цэг хүртэл 5500 км, зүүнээс баруун цэг хүртэл 5200 км, 15 улстай хуурай газраар, 6 улстай усаар хиллэдэг.

Улсын хэмжээгээр 23 шэн (аймаг), 5 өөртөө засах орон, шууд харъяаны 3 хоттой. Хүн ам нь 1,3 тэрбум, 56 үндэстэн ястнаас бүрддэг. Хан үндэстэн нийт хүн амын 91,9 хувийг эзэлдэг. Хуй ба Ман үндэстэн хятад хэлийг хэрэглдэг, бусад 53 үндэстэн өөрийн хэлээр ярьдаг бөгөөд 23 үндэстэн нь өөрийн гэсэн бичиг үсэгтэй.

Монгол – Хятадын хил 4673 км урт үүнээс: хуурай газраар 4482,3 км, ой модтой газраар 14,2 км, нуур гол горхийн усаар 190,4 км хиллэдэг. Манай улсын Баян - Өлгий, Ховд, Говь – Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнод 8 аймаг, 39 сум, БНХАУ-ын Шинжаан – Уйгарын өөртөө засах орон, Хэйлунизияйн, Гирийн муж 10 аймаг, 21 хошуутай хиллэдэг. Ховдын Булган сум, Дорноговийн Замын - Үүд, Дорнодын Халх гол сум, Сүмбэр сангийн аж ахуй улсын хилээс 4,5-25 км, бусад газрууд 300 хүртэл км зайд оршдог.

БНХАУ нь арми, зэвсэгт цагдаа, аюулаас хамгаалах байгууллага, хилийн бүсийн ард иргэдээс бүрдсэн нэгдсэн системээр хилээ хамгаалж байна.

Хятадын хил хамгаалалтын энэ систем нь “Нэг төр, гурван шугам” гэсэн томъёоллоор явагддаг. Үүнд:

Нэгдүгээр шугам нь: ХАЧА-ийн хил хамгаалалтын хороо, батальон, суман, постын хүч хэрэгслээр хамгаалахыг хэлнэ.

Хятадын хилийн хороо, гэдгээрийн батальон, ротууд (суман) нь улсын хилээс дотогш 2-3 км зурвас хэсгийг хамгаалдаг бөгөөд энэ нь хил хамгаалалтын нэгдүгээр зааг болдог гэж үздэг.

Монгол улсын хилийн дагуу Бээжин, Ланьчжоу, Шэньяны цэргийн тойргийн харъяа Шинжянь, Ганьсу, Өвөрмонголын салбар цэргийн тойргийн 123 штаб, явган цэргийн 13 дивиз, нисэхийн 3 хороо хилээс 150-300 км-т байрлаж, хил халхлалтын үүрэг гүйцэтгэж байна. улсын хилийн шугамнаас 20-170 км-т радиолокаторын постууд байрлаж, манай нутгийн гүнд 350 км хүртэл радиустайгаар агаарын тагнуул явуулахын зэрэгцээ агаарын хилийг хамгаалж байна.

Улсын хилийн шугамнаас 25-30 км-ийн гүнд 20 мянга гаруй цэрэгтэй хилийн 9 хороо хил хамгаалалтыг зохион байгуулж байна. Хилээс 0,6-50 км-ийн гүнд тус бүр нь 60-120 хүнтэй хятадын хилийн 87 рот (суман) байрлаж дунджаар 50 гаруй км хилийн хэсгийг хариуцах бөгөөд хилээс 0,1-18 км-ийн гүнд харуулын байнгын пост, 10-30 орчим метр өндөр төмөр болон бетонон хянах цамхагаас манай нутагт хяналт тавьж байна.

Сүүлийн үед хил хамгаалалтанд цэргийн хүч хэрэгслийг байнгын байрлалаас ердийн болон техникийн хяналтыг идэвхижүүлэхэд голчлон анхаарч байгаагаас гадна морин ба автомашин уналгатайгаар хилийн тодорхой хэсэгт 5-7 хүний бүрэлдэхүүнтэй харуул, сэргийлэх, нууц манаа томилох, ул мөрийн шалгалт хийх, багана, тэмдэгт шалгахад ашиглаж байна. Мөн шаардлагатай үед нисдэг тэрэг ашиглаж байна. Байнгын посто өглөө, оройн цагаар, заримдаа шөнийн цагаар нууц хянах постуудыг халалцуулдаг ба байнгын постууд нь хилийн сумантайгаа радиостанцаар харьцдаг байна.

ХИЛ СУДЛАЛ

Хятадын тал хил хамгаалалтандаа онцгой анхаарч, хилийн улаан шугамнаас 5-25 метрийн зайтайгаар 12 эгнээ бүхий давхар ган утас, 1,6 метрийн өндөртэй цемэнтэн шон болон дээгүүрээ холбооны утас бүхий тор таган, түүний цаагуур сайжруулсан шороон зам тавьж, мөр хянах зурвасаа жилдээ 2 удаа сэргээн, хилийн бүрх суман, томоохон постоо дахин дамжуулах радиорелейны цамхаг байгуулж, хилийн манаа нь цаг агаарын ямар ч нөхцөлд найдвартай холбоогоор хангагдаж, цэц мэргэ сайтай мөрлөгч бүхий АК төрлийн буугаар зэвсэглэсэн байна.

БНХАУ-ын ШУӨЗО нь Монгол улстай болон ОХУ, Казакстан, Тажикстан улстай хиллэсэн хилийн хэсэгт хилийн инженерийн хамгаалалтыг бэхжүүлж, бетонон шонтой олон давхар торон хамгаалалтыг байгуулж дуусган, 2001 оны сүүлчээр ШУӨЗО - ны тусгай комисст хүлээлгэж өгсөн байна.

Хятадын хил хамгаалалтын системд шинэ техник, технологи нэвтэрч байна. Тухайлбал: Амгалангийн хилийн хорооны Алтан - Эмээлийн батальоны Хамбаарын ротод тодорхой цагт хиймэл дагуулаас шууд мэдээлэл авах, дамжуулах, чагнах (манай радиоторыг сонсох) станцыг туршилтын журмаар суурьлуулан ажиллуулж байв. Мөн хятадын хилээр хууль бусаар автомашин гаргадаг чиглэлүүдэд хилийн дагуу татсан торныхоо хаалга болон түүний ойролцоох газруудад автомашин саатуулах зориулалт бүхий "зараа" хэлбэрийн төмөр хавтгайг өнгөлөн далдлаж байрлуулжээ. Хятадууд хянах цамхагуудад 25-40 км-ийн гүнд хяналт зохиох хүчин чадал бүхий дуран харааны хэрэгсэл суурьлуулан ажиллуулж байна.

Хоёрдугаар шугам нь: хилийн хошуу, сумдын Аюулаас хамгаалах байгууллага, Дотоодыг хамгаалах товчоо, Зэвсэгт цагдаагийн хүч хэрэгслээр хамгаалахыг хэлнэ.

Манай улстай хил залгаа Хятадын өөртөө засах орон, муж бүрд Аюулаас хамгаалах тэнхим, аймгуудад хамгаалах товчоо, сумдад тагнуулын ажилтан ажиллаж гүйцэтгэх ажлын шугамаар улсын хил хамгаалалтыг зохион байгуулдаг.

Хятадын хилийн хороод нь тагнуулын хэлтэстэй бөгөөд улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалахад гол үүрэг

гүйцэтгэж, хилийн бүс дэх Хятадын тусгай албадтай харилцан ажилладаг ба манай талтай хийгдэж буй хилийн уулзалтыг зохион байгуулдаг.

Хилийн аймаг, хошуудад Зэвсэгт цагдаагийн их, дунд ангиуд хил хамгаалалтыг гүнд нь зохион байгуулдаг байна. Хилийн бүсийн аймгуудад 70-80 хүнтэй зэвсэгт цагдаагийн их анги, хошуу бүрд зэвсэгт цагдаагийн дунд анги, сумдад түүний салбарууд байрладаг байна. Зэвсэгт цагдаа нь нийгмийн хэв журам сахиулдагийн хувьд НАХЯ-нд, улсын хил хамгаалалтанд оролцдогийн хувьд цэргийн салбар тойрогт захирагдаж, хилийн хороо, батальон, сумангуудтай байнгын харилцаа холбоотой ажилладаг. Зэвсэгт цагдаа нь хилийн түр боомтууд нээгдэн ажиллах хугацаанд шалган нэвтрэх албаны үүргийг гүйцэтгэдэг. Мөн хил зөрчигч, хил давсан малыг уулзалтаар хүлээлгэн өгөх үед хилийн уулзалтын бүрэлдэхүүнд орж ажилладаг.

Гуравдугаар шугам нь: Хилд тулж нутаглан ажил үйлдвэрлэл эрхэлж буй малчид, ажилчдын хүч хэрэгслээр хамгаалахыг хэлнэ.

Хилийн районы оршин суугчид нь буу, дурангаар хангагдан хуваарилсан хилийн шугамын дагуух тодорхой хэсгээр гадаад, дотоодоос хилийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хилийн зөрчил, бусад гэмт үйлдлийн талаар мэдээлэх, манай хилийн дагуух хөдөлгөөнд хяналтыг идэвхитэй зохиох, ул мөрийг шалгах, торны хаалганы хамгаалалтыг хариуцах зэргээр хил хамгаалалтанд оролцдог.

Хил хамгаалалтанд оролцдог хүмүүсийг хаана нутаглах, ямар багана, хэсгийн торыг хариуцах, засах, хяналт зохиох, хилийн зөрчлийн асуудлыг хэрхэн яаж мэдээлэх зэрэг асуудлыг хилийн сумдын намын дарга нар хариуцан зохион байгуулдаг.

Хятадын хил хамгаалалт дараах онцлогтой байна.

1. Эдийн засгийн давуу талаа ашиглан хилийн инженер техникийн хангалтыг үндсэндээ шийдсэн. Хилийн дагуу 2м өндөртэй бетонон шонтой торон хашааг босгосон. Хилийн дагуух замаа бүрэн засварласан. Хилийн станц, ротууд ачааны болон суудлын

ХИЛ СУДЛАЛ

автомашин, мотоцикль, цасны чарга өргөн ашиглах болсон. Говь, тал хээрийн бүсэд бие биеэ харсан хянах цамхагууд байгуулсан.

2. Улсын хилийг Хятадын ардын чөлөөлөх армийн анги нэгтгэлүүд хамгаалж, шалган нэвтрүүлэх боомт, түүний зурвас, гүнийг НАХЯ-ны хилийн цэрэг хамгаалдаг.

3. Хятадууд улс төр, дипломатын аргаар улсын хилийг хамгаалахад онцгой анхаарч байна.

4. Улсын хилийг өдрийн цагт гусгай төхөөрөмжилсөн хянах цамхагаас хянаж, шөнийн цагт хилийн манаагаар хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

5. Хил хамгаалалтанд тагнуулын байгууллага асар том үүрэг гүйцэтгэж байна. Тагнуулын ажилтнууд хилийн төлөөлөгчийн орлогчийн хэмжээнд ажилладаг бөгөөд тэд их эрх мэдэлтэй байгаа нь ажиглагддаг.

6. Хил орчмын ард иргэдийн хил хамгаалалтанд тусгай үүрэгтэйгээр оролцуулж тэдний хилийн цэрэг байнга шалгаж үүрэгжүүлж байдаг.

7. Хилийн тухай хууль тогтоомжоо чангатгасан. Хилийн дэглэм зөрчсөн, малаа хил давуулсан хүмүүст өндөр торгууль оногдуулдаг. Иймээс иргэд хилээ, хилийн цэргээ хүндэтгэдэг.

8. Хилийн албаны гол гол албан тушаалд хятад хүмүүс томилогдсон хэвээр байна.

9. Хил дээр ажиллаж буй албан хаагчдын цалин хангамжийг байнга нэмэгдүүлж байна. Хилчид авилгалд өртөх, хилийн зөрчилд холбогдвол тухай бүрд нь арга хэмжээ авч байна.

10. ХАЧА болон дотоодын хамгаалахын цэргийн албан хаагчдын улс төр байлдааны бэлтгэл сургуульд ихээхэн анхаарч байна. Хилийн уулзалт хэлэлцээний үед буудлага хийлгэх, олон төрлийн дасгал гимнастик хийж үзүүлэх зэргээр өөрийн цэргийн сүр хүчийг гайхуулдаг болсон.

Хоёр. Оросын Холбооны Улсын хил хамгаалалт

ОХУ нь хүн ам 150 сая, 170.754 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй. 16 улстай хиллэдэг бөгөөд үүнээс хуурай газраар 13, усаар 3 улстай хиллэдэг. Хойт мөсөн далай, Атландын далай, Номхон далай зэрэг гурван их далай. 10 тэнгисээр хүрээлэгддэг.

ОХУ-ын хилийн нийт урт 61031,29 км, үүнээс хуурай газрын хил 22224 км, усан хил 38807 км, эдийн засгийн бүс 8456 сая хавтгай дөрвөлжин км.

Улсын хил дээр 900 застав, 382 шалган нэвтрүүлэх боомт байрлан үүрэг гүйцэтгэдэг. ОХУ-ын улсын хилд өдөр бүр 11000 хилийн манаа, 95-100 хөлөг онгоц, катер, 80-90 нисдэг тэрэг, нисэх онгоц томилогдон албан үүрэг гүйцэтгэдэг.

Манай улстай хиллэдэг хилийн хэсэгт ОХУ-ын Холбооны Хилийн албаны Өвөрбайгалийн бүс нутгийн удирдах газрын Акташ, Кызыл, Хиагт, Мангут, Даурын хилийн отряд улсын хилийн хамгаалалтыг явуулж байна. ОХУ-ын Хакасын нийслэл Абакан хотод Акташ, Кызылийн хилийн отрядыг Чита мужийн Акшийн районы төв Акша хотод Хиагт, Мангут, Даурын отрядуудыг тус тус шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий оператив цэргийн бүлэг ажилладаг.

Хилийн отряд бүр хилийн төлөөлөгчийн аппараттай юм. Хилийн төлөөлөгчийн аппарат нь хилийн хамгаалалтыг удирдан зохион байгуулдаг бөгөөд хилийн хамгаалалтаа хилийн отряд, заставуудын бие бүрэлдэхүүн, инженер техникийн хэрэгсэл, орон нутгийн туслах хүчин, гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэлд тулгуурладаг. Хилийн төлөөлөгчийн аппарат нь хилийн отрядаа, хилийн отряд нь коминпатураа, коминдатур нь хилийн заставуудаа өдөр тутмын удирдлагаар хангаж ажилладаг байна.

Баян - Өлгий аймагтай хиллэдэг Уулын Алтай улсын хилийн хэсэгт Акташийн хилийн хорооны Аргамж, Бийск, Ташантын хилийн застав, Кош – Агачийн хилийн коминдатур, Ташантийн ШНБ хил хамгаалалтыг зохион байгуулдаг.

Хил хамгаалалтыг байнгын болон түр хянах харуулаар, мөн өдөр бүр шөнийн цагт хилийн манаагаар болон гүйцэтгэх ажлын хэрэгслээр хамгаалалтыг зохион байгуулдаг.

Ташантын ШНБ дээр тагнуулын офицер суурин байрлаж ажилладаг. Увс аймагтай хиллэдэг Тува улсын хилийн хэсэг нь Монгол Оросын хилийн эмзэг цэг хэвээр байна. Энэ хэсгийн хил

ХИЛ СУДЛАЛ

хамгаалалтыг Кызылийн отрядын харъяа Хандгайтын коминдатур, Хандгайтын ШНБ, Шар суурь, Торхилог, Мухар агсаа, Сагил, Кызылийн хилийн заставууд зохион байгуулдаг.

Завхан аймагтай хиллэдэг хилийн хэсгийн эсрэг талд Кызылийн хилийн хорооны Цагаан толгойн застав хил хамгаалалтыг зохион явуулдаг ба ШНБ-ын үүргийг давхар гүйцэтгэдэг.

Кызылийн хилийн хорооны хариуцсан хэсэг болох манай улсын Хөвсгөл аймагтай хиллэдэг хилийн хэсэг буюу 466 км газарт хилийн ганц ч застав байхгүй бөгөөд зөвхөн зун, намрын улиралд хилийн 304 дүгээр тэмдэгийн чиглэл дэх Тарисын халуун рашаан, хилийн 304 дүгээр тэмдэгийн чиглэл дэх Ушбэлдэрийн рашаан дээр тус бүр "Погранстраж" –ийн 5-7 хүн 7-30 хоногийн хугацаагаар ирж рашаан орчмын иргэдийн бичиг баримт шалгадаг ба Кызылийн отрядын тагнуулын ажилтнууд үе үе нисдэг тэргээр хүргүүлэн ажилладаг байна.

Манай улсын Хөвсгөл аймагтай 922 км газраар хиллэдэг Буриадын улсын хилийн хэсэгт Хиагтын отрядын Мондийн застав 20 орчим км газрыг хамгаалдаг ба бусад хэсгийг хамгаалалтгүй орхидог. Энэ хэсгийг манай хилийн 7 суман хамгаалдаг.

Буриад улсын Закаменск район дахь Нуртын застав барих ажиллагаа санхүү мөнгөний бэрхшээлээс түр хугацаагаар зогсонги байдалд орсон бөгөөд одоогоор уг заставын барилга бүрэн баригдаж дуусаагүй байна.

Хил хамгаалалтанд УАЗ – 469, ГАЗ – 66 маркийн автомашин, радиотехникийн хэрэгсэл, ПСНР- 5, гэрэлтүүлэгч техникийн хэрэгсэл АПМ – 90, ФАС – 4, шөнийн болон өдрийн харааны хэрэгсэл Б – 12, Б – 1, ТЗК холбооны хэрэгсэл Р - 392, АЙВА, Сокол – МЗ, Р – 130, Р – 143, зэвсэглэл АКМ, АКМС, РПК, ПКТ, ПМ, СВД, РПГ, дохионы буу, уналгын морь, эрлийн нохой ажилладаг. Хилийн заставууд нь мөр хянах зурвас, дохиоллын систем, С – 100 торон хашаатай байна.

Сүүлийн үед Кызылийн хилийн отрядын бензин, шатахуун, хүнс, хэрэглэл зэрэг ар талын хангалтанд ахиц гарснаар хил хамгаалалт нь илүү идэвхитэй хэлбэрээр явагдаж байна. Оросын талын нэг застав 3-5 тн бензиний нөөцтэй, хүчлэн хамгаалалтанд тагнуулын офицерууд үүрэг гүйцэтгэж, хилийн цагийн байдлыг хянаж байна. Мөн хил хамгаалалтанд нисдэг тэрэг хэрэглэж байгаа нь хил хамгаалалтыг үр дүнтэй болгохоос гадна, хилийн дагуух манай талын хүн малын бөөгнөрөл, хилийн харуулын манаа, сумангуудын үйл ажиллагааг хянах боломжтой юм.

ОХУ-ын Уулын Алтай, Тыва, Буриад улс, Чита мужийн 18 районд Холбооны аюулаас хамгаалах хэлтэс, хилийн 5 хороо тус бүрд цэргийн болон цэргийн сөрөг тагнуулын хэлтэс, Хиагтын дивизед цэргийн тагнуулын 2, цэргийн сөрөг тагнуулын хэлтэс нийт 32 хэлтэс ажиллаж байгаа бөгөөд улсын хилийн хамгаалалтанд гүйцэтгэх ажлын шугамаар идэвхитэй оролцдог. Хилийн застав бүрд 1-2 тагнуулын ажилтан байнга ажиллдаг бөгөөд Кызылийн хилийн отрядын Хандгайт, Шар суурийн заставууд нь тагнуулын тасагтай байна.

Наушкийн ШНБ нь бие даасан анги бөгөөд цэргийн болон сөрөг тагнуулын тасагтай, Хиагтын ШНБ нь Наушкийн боомтод харьяаллагддаг. 2001 оноос эхлэн хугацаат цэргийн албан хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэхээ больж, зөвхөн гэрээт хил хамгаалагчдаар ШН албыг зохион явуулах болсон. Нийт шалгагч нарын 70 хувь нь эмэгтэй шалгагч нар болсон байна.

Оросын тал “Погранстраж” “Спец. ДНД” буюу “Сайн дурын ардын тусгай бүлэг” гэсэн Тыва иргэдээс бүрдүүлсэн хил хамгаалалтын нэгжүүдийг байгуулан ажиллуулж байгаа боловч эдгээр хүмүүс малын хулгайч нартай хуйвалддаг байна.

Погранстражийн бүрэлдэхүүнд цэргийн цол өгч, Кызылийн отрядаас “Спец ДНД”-ийн хүмүүсийг орон нутгийн засаг захиргаанаас тус тус цалинжуулдаг.

ОХУ-ын Буриадын Закаменск, Галуут нуур район, Чита мужид хил хамгаалалтыг казакуудын сайн дурын хил хамгаалах бүлэглэлүүдийн хүчээр явуулж байгаа ба үүнд буриад залуучууд

ХИЛ СУДЛАЛ

орохыг зөвшөөрч, 35 нас хүртэлх залуучуудыг сайн дурын үндсэн дээр бүртгэж байна. Казакуудын бүлэглэлийн гишүүд нь өөрсдөө морь, хувцас зэргээ бэлтгэдэг ажээ.

2001 оноос ОХУ, “Хилийн хамгаалалтын шинэ үзэл баримтлал” гаргаж хэрэгжүүлж байна. Урьд нь хил хамгаалалтын үндсэн арга хэлбэр нь цэргийн хүч байсан ба тагнуул, оператив эрлийн ажиллагаа, техник хэрэгсэл ашиглах нь хил хамгаалалтын хангалт гэж үздэг байсан бол одоо хил хамгаалалтын үндсэн арга хэлбэр болгон ашиглаж цагийн байдлын зайлшгүй шаардлагатай үед цэргийн хүчийг ашиглах арга хэлбэрт шилжиж байна.

Оросын Холбооны Улсын хил хамгаалалт дараах онцлогуудтай байна.

Үүнд:

1. Улсын хилийг гүйцэтгэх ажлын хэрэгслээр хамгаалах, халхлахад онцгой анхаардаг. Энэ нь хил хамгаалалтын гол арга хэлбэр болсон.

2. Улсын хил хамгаалалтанд орон нутгийн ард иргэд, хилийн цэрэгт туслах хүчийг өргөнөөр ашиглахын зэрэгцээ сайн дурын ардын тусгай бүлэг, казакуудын уламжлалт бүлгүүдийг (казачество) зохион байгуулан удирдлагаар ханган ажиллуулж байна.

3. Улсын хил хамгаалалтанд орон нутгийн байгууллага, удирдлагуудын оролцоог шефийн холбоо тогтоох хэлбэрээр өргөн ашиглаж эдийн засгийн ихээхэн туслалцааг авдаг.

4. Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах үүргийг отрядын удирдлагаас салган тусгай мэргэшсэн бүрэлдэхүүнээр явуулдаг болсон.

Гурав. Израиль улсын хил хамгаалалт

Израиль улс нь улсынхаа хил хамгаалалтыг үндсэндээ техникжүлсэн бөгөөд хил хамгаалалтын түвшингээрээ дэлхийд дээгүүрт тооцогддог. Иймээс хөрш зэргэлдээ орнуудын хил хамгаалалтын зэрэгцээ хил хамгаалалтыг сайн зохион байгуулдаг, зэвсэг техникээрээ дэлхийд дээгүүр тооцогдох болсон нь Израиль улсын хил хамгаалалтын талаар та бүхэнд танилцуулж байна.

Сүүлийн үеийн Ойрхи Дорнодын талаархи хэвлэлийн мэдээнд алан хядах ажиллагаатай тэмцэж буй цэрэгжүүлсэн байгууллага “ногоон цагдаа” –гийн талаар ихээр дурьдагдах болсон. Энэ бол малгай, хувцасныхаа өнгөөр нэрлэгдэх болсон Израйлийн хил хамгаалагч нарын тухай яригдаж байгаа юм.

Энэ байгууллага нь зарим талаараа зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэдэг боловч, БХЯ-нд шууд захирагддаггүй. Мөн Франц, Итали, Испанитай адил Дотоод явдлын яамандаа захирагддаггүй. Харин Үдэсний цагдаагийн бүрэлдэхүүн хэсэг юм.

Хил хамгаалалтын өдөр тутмын удирдлагыг түүний дарга хангадаг бөгөөд Үндэсний цагдаагийн ерөнхий байцаагчид захирагддаг. Хил хамгаалах байгууллага нь 1953 онд байгуулагдсан бөгөөд түүний үйл ажиллагаа төрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулагддаг, байгуулагдсаныхаа эхэн үед нүүдэлчин омог □ бедунчуудын улсын хилийг хууль бусаар зөрчих явдалтай тэмцэхэд чиглэгдсэн байжээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам байгууллагын үүрэг улам өргөжин өөрчлөгдөх болов. Энэ нь Израйль улс болон түүний эзэлсэн нутаг дэвсгэр дээр алан хядах ажиллагаа ихэссэн мөн Палистины болон Ливаны “Хезболлох” зэвсэгт бүлгүүдийн үйл ажиллагаа хил орчмын нутаг дэвсгэрт идэвхжсэнтэй холбоотой.

Орчин үед Израйлийн ХХБ нь сайн сургаж бэлтгэсэн сайтар зэвсэглэгдсэн бие бүрэлдэхүүнтэй анги, салбарууд нь үндсэндээ 1967, 1973 оны Араб, Израйлийн дайны дараах эзэлсэн нутаг дэвсгэрүүд болон Тель – Авив, Иерусалим хотуудад байрладаг.

1974 оноос хойш Засгийн газрын шийдвэрээр Израйлийн хилийн цэрэг хот болон хөдөөгийн районы аюулгүй байдлыг хангах агаарын болон далайн усан боомт, улс ардын аж ахуй, үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн онц чухал объектуудыг хамгаалах болсон.

Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Израйлийн хилийн цэрэг өнөөдрийн байдлаар алан хядах ажиллагаатай тэмцэх гол хүч болжээ.

ХИЛ СУДЛАЛ

Мөн тодорхой үүргийн хүрээнд зэвсэгт хүчин болон цагдаагийн зарим үүргүүдийг биелүүлдэг байна. Тухайлбал: Иордан голын баруун эрэг болон газрын зурваст дэг журам сахиулах, Палистины нутаг дэвсгэрт армийн анги салбарууд тусгай ажиллагаа явуулахад туслах, Палестины цагдаагийнхантай хамтарсан эргүүл хийх, онц чухал объектийг хамгаалах гэх мэт.

Хил хамгаалах байгууллага нь мөн цагдаагийн ердийн үүргийг биелүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах сайн дурын байгууллагатай ажиллах зэрэг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд цагаачдын хөдөлгөөнд хяналт тавих, төмөр зам, агаарын болон усан замын буудлуудад дэг журам сахиулах, агаар, усан, хуурай хилээр нэвтрэх ажиллагааг хянах, дамын наймаа, хар тамхитай тэмцэх, тусгай албадын ашиг сонирхолд зориулан хилийн зурвас дахь цагийн байдлын мэдээг цуглуулан боловсруулах үүрэгтэй.

Мөн байгалийн гамшиг болон бусад шаардлагатай нөхцөлд аврах, сэргээн босгох ажиллагаанд оролцох үүрэг хүлээдэг. Хилийн хамгаалалтанд 8000 хүн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үндсэндээ ЗХУ болон Эфиопоос гаралтай еврейчүүд юм.

Бие бүрэлдэхүүний 12 хувь буюу 960 орчим нь үндэсний цөөнхийн төлөөлөл, ХЦ-т алба хаах хугацаа 3 жил, 1996 оноос эхлэн ХЦ-ийн байлдааны анги салбарт эмэгтэйчүүд алба хаадаг болсон. Хил хамгаалах байгууллагын дарга нь 6 бүс нутгийн удирдлагаас бүрдэх штабаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг хил хамгаалалтын байгууллагын анхан шатны нэгж нь рот бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах болон бусад ажиллагааг чадварлаг гүйцэтгэдэг. Гол сургалтын төв нь Иерусалим хотын ойролцоо Бейт – Хоронд байрладаг.

Сургалтын төлбөр нь цагдаагийн ажиллагаа болон хуурай замын цэргийн тактик ажиллагаанд сурахад чиглэдэг. Алан хядах ажиллагаатай тэмцэх тусгай асуудлыг Үндэсний цагдаагийн сургуульд судалж, хотын нөхцөлд байлдаан явуулах, тактик ажиллагаа, барилга байгууламж, объектийг дайран эзлэх, төр засгийн өндөр албан тушаалтнуудыг хамгаалах арга ажиллагаанд сургадаг. Сургалтыг байлдааны ойртуулсан нөхцөлд явуулж,

буудлагыг будагтай сумаар үйлддэг. Ердийн хил хамгаалах анги, салбараас гадна тусгай салбарууд үүрэг гүйцэтгэдгээс хамгийн том нь “Ямам” юм.

1974 онд байгуулагдсан энэ анги нь барууны цэргийн мэргэжилтнүүдийн дүгнэлтээр бол дэлхийн хамгийн сайн бэлтгэгдсэн тусгай салбаруудын нэг бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэхэд арми, цагдаад туслах, барьцаалагчдыг чөлөөлөх, төр засгийн тэргүүнүүдийг алан хялах ажиллагаанаас хамгаалах тусгай үүргийг биелүүлдэг.

Израиль нь төрөл бүрийн буудлагын зэвсэгийн үйлдвэрлэлт ба нийлүүлэлтээрээ алдартай бөгөөд хил хамгаалалтын анги салбарууд нь “Газил – Узи” маркийн хамгийн сүүлийн үеийн зэвсэгтэй. “Узи” автомат нь техникийн гол үзүүлэлт болох янз бүрийн нөхцөлд ажиллах өндөр чадвартай, бага овортой (эвхэгддэг мөрлөгчтэй, урт нь 47 – хон сантиметр), буудлагын хурд 600 сум/минут, дайз нь 20,25,32 сумны багтаамжтай. Офицеруудын хувийн зэвсэг нь 9мм-ийн “Жирико” – 941 FDA бөгөөд дайз нь 16 сумны багтаамжтай, шөнө ба өдөр буудахад зориулагдсан овоо хараатай, хосолсон гал хамгаалагчтай, (нэг нь магазиныг салгах үүрэгтэй), тусгал, ончийг сайжруулах зорилгоор гол төмрийн сувагт тусгай, олон өнцөгт ховилтой, байнгын цэнэгтэй байдлаар авч явах аюулгүй нөхцөлийг хангасан буу юм.

Хил хамгаалах анги, салбар, цэргүүд нь тусгай хэрэгслээр сайтар хангагдсан бөгөөд хамгаалалтын малгай, хантааз, орчин үеийн холбооны хэрэгсэл, дуу чимээний ба хийн гранат, шөнийн дуран харааны хэрэгсэлтэй бөгөөд туулалт сайтай, хуягласан, сум үл нэвтрэх шилтэй, шатаах зэвсэгээс бүрэн хамгаалагдсан “Суфа” маркийн жип автомашин ашигладаг.

Сүүлийн үеийн хил хамгаалалтад хилийн инженерийн ажлыг гүйцэтгэх зориулалттай мини – тракторуудыг өргөнөөр ашиглаж байна.

Израиль улс нь улсын хилээ компьютерийн бүрэн хяналтанд авсан бөгөөд уг систем нь нэг оператор нь компьютерий тусламжтайгаар 250км урт хилийн хэсгийг хянах, мэдээллийг

ХИЛ СУДЛАЛ

цуглуулах боломжтой. Хяналт хийхэд хүндрэлтэй хэсгийг шалгахдаа операторын удирдлагаар нисгэгчгүй нисэх онгоц хөөргөн зураг авч, боловсруулалт хийн цагийн байдлыг үнэлдэг. Уг онгоц агаарт тасралтгүй 3 цаг нислэг үйлдэх боломжтой.

Хил хамгаалах байгууллага нь Израйлийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж байна гэж гадаадын цэргийн мэргэжилтнүүд өндрөөр үнэлсээр байна.

Израйль улсын хил хамгаалалт нь дараах онцлогуудтай байна.

1. Улсын хилээ техникийн бүрэн хяналтад авсан. Энэ нь өртөг өндөртэй боловч нэгэнт байгуулагдсан тохиолдолд хүн хүч хэмнэсэн, ашигт үйлийн коэффициент өндөр, найдвартай хамгаалалт, халхлалтыг бий болгодог.
2. Хүн нэг бүр, анги салбаруудын бэлтгэлийн түвшин өндөр, орчин үеийн зэвсэг техник хэрэгслээр бүрэн хангагдсан.
3. Хил хамгаалах байгууллага нь улсын хил хамгаалалтын гадна тусгай үүргүүдийг гүйцэтгэдэг бөгөөд уг чиглэлээрээ өндөр дадлага чадвар эзэмшсэн, мэргэшсэн.
4. Хил хамгаалах байгууллагын дарга нь бүс нутгийн удирдлагаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг.

*Докторант, дэд хурандаа Ц.Ганболд (ХЦДС)
Докторант, дэд хурандаа Ц.Доржням (ТЕГ)*